МОНГОЛ ШУУДАН

*Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани*



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021

1921 100 ЖИЛ

ЦАХИМ ҮНДЭСТЭН



# "МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021

Фото зургийг **Тэгэл**
*Аглагийн хийд*

# АГУУЛГА




**КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ**

6 Мэндчилгээ

8 Төлөөлөн удирдах зөвлөл

10 Компанийн 2021 оны зорилго, зорилтууд

12 Монгол Шуудангийн түүх

14 Цар тахал ба хямралын менежмент

19 2021 оны онцлох амжилтууд

**ХҮНИЙ НӨӨЦ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААР**

26 Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар

28 2021 оны ололт амжилт

29 **ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛАВЛАХ ТӨВ**

34 **ЦАХИМ ШИЛЖИЛТ АЖЛЫН ХҮРЭЭНД**

36 **ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД**

38 **УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

**ДОТООД ШУУДАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

40 **Шуудан солилцооны бүртгэл, судалгаа**

**ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД**

42 Хот доторх хүргэлт буюу гараас-гарт хүргэлтийн үйлчилгээ

43 **Улс хоорондын транзит шуудангийн үйлчилгээ**

43 **Хот хоорондын тээвэр, логистикийн үйлчилгээ**

**САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АЖЛЫН ХҮРЭЭНД**

44 Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

**МАРК ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД**

46 Марк үйлдвэрлэл

48 Дугтуй, үнэт цаасны үйлдвэрлэл

50 **САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

59 **АУДИТЫН ТАЙЛАН**

МОНГОЛ ШУУДАН

Хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

Уламжлал ёсоор 17-р жарны Сайжруулагч хэмээх Усан Бар жилийн эхний улиралд Компанийнхаа жилийн тайланг хувьцаа эзэмшигч танд хүргэн мэндчилж байгаадаа баяртай байна.



Өнгөрч буй 2021 он бүхэлдээ цар тахалтай нүүр тулсан, Монгол улс төдийгүй дэлхий нийтээр бүх нийтийн болон өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжиж хатуу хөл хорио тогтоосон, улс орон, албан байгууллага бүрийн хувьд үйл ажиллагаа хумигдаж, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, хүндрэл бэрхшээлийг хохирол багатайгаар даван туулахад чиглэсэн томоохон сорилтын жил байлаа. Гэсэн хэдий ч Монгол шуудан компанийн хувьд энэхүү сорилт, бэрхшээлийг боломж болгон ашиглаж компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрвөх чадварыг сайжруулах тал дээр анхаарч, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг цаг тухай бүрд нь ханган ажиллаж шуудангийн үйл ажиллагааг нэг өдрөөр байтугай нэг цагаар ч тасалдуулалгүй, бүх нийтийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй, хариуцлагатайгаар биелүүлэн амжилттай даван туулсандаа баяртай байна.

*Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани*

Мөн 2021 онд Монгол улсад орчин цагийн харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой тохиож бид түүхэн ололт амжилт, алдаа оноогоо дүгнэн хэлэлцэж, 2017 онд шинээр боловсруулсан компанийн дунд хугацааны хөгжлийн бодлого буюу 5 жилийн стратеги төлөвлөгөөний зорилтуудаа 100% амжилттай биелүүлж, компанийн зах зээлийн үнэлгээ 100 жилийн түүхэнд анх удаагаа 100 тэрбум төгрөгөөс давсан зэрэг ололт амжилтаар дүүрэн жил байлаа.

Монгол улсын харилцаа холбооны салбарын сүүлийн 100 жилийн хөгжлийн түүхэнд шуудан холбоо буюу өнөөгийн Монгол шуудан ХК тэргүүлэх үүргийг хүлээж ирсэн бөгөөд цаашдаа ч бид нэгэн зууны бахдам түүхийг үргэлжлүүлэн шилдэг боловсон хүчин, ухаалаг үйлчилгээ, технологи орчинг бүрдүүлэн, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалтай хөл нийлүүлэн цахим шилжилтийг түүчээлэн хийж дэлхийд тэргүүлсэн дижитал шуудан, хүргэлт, логистикийн компани болох зорилго тавин ажиллаж байна.

Эрхэм та манай компанийн 2021 оны жилийн тайланг хүлээн авна уу.

Гүйцэтгэх захирал
**Бадамрайн АНХБААТАР**

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Даваахүү**
**НАРАНГЭРЭЛ**
ТУЗ-ийн дарга



**Даваасамба**
ДЭЛГЭРМАА
ТУЗ-ийн ердийн гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга



**Гэрэлт**
ТЭЛМЭН
ТУЗ-ийн ердийн гишүүн



**Одончимэд**
ОДБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн
Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны дарга



Ванчиг
ГАНЗОРИГ
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Энхбаатар**
БАТ-ИДЭР
ТУЗ-ийн ердийн гишүүн



**Нэргүй**
МЯГМАР
ТУЗ-ийн ердийн гишүүн



**Банзрагч**
ГАНБААТАР
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Дарамбазар
БАЛДОРЖ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга

*Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани*



Фото зургийг **Төгөл**
Баян-Өлгий

# КОМПАНИЙН 2021 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ШУУДАНГИЙН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОХ

ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ КОМПАНИ БОЛОХ

САНХҮҮГИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОХ

СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

# МОНГОЛ ШУУДАНГИЙН ТҮҮХ

1921-2022 он



Шуудан харилцаа нь Хүнну гүрний үеэс, он цагийг илүү наашлуулбал их эзэн Чингис хааны хүү Өгөдэй хааны дөрвөн сайн үйлийн нэг болох сайтар зохион байгуулсан өртөөт зам “Монголын Морин Өртөө”-нөөс үүсэлтэй.

Монголын морин өртөө шуудан нь үүсэл хөгжлөөрөө дэлхийн шуудан холбооны түүхэнд анхдагч тэргүүн зэргийн харилцаа холбооны нэгэн төрөлд тооцогддог билээ.

Монгол улс дэлхийн асар өргөн уудам нутгийг эзлэн оршиж байсан үед 1228-1241 онд Монголын эзэнт гүрний хаан ширээнд сууж байсан Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгөдэй мэдээлэгч, захирагч нарыг бий болгож морин өртөө байгуулсан нь шуудан харилцааны хувьд уургын улаан халж, мэдээлэл харилцаа дамжуулах сүлжээг үүсгэн байгуулсан томоохон дэвшил билээ.

Өртөө нь улам боловсронгуй болон хөгжсөөр Ардын хувьсгал мандсан 1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан нь одоогийн 100 жилийн түүхт Монгол Шуудан юм.



*Шуудан хуваарилах тасаг. 1950 он*




*Шуудanч бүсгүй. 1980 он*

| | |
|---|---|
| 1921-07-19 | Ардын Засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулав. |
| 1935 | Нийслэлийн Шуудангийн хороо |
| 1935-1936 | Нийслэлийн Төв Холбооны Төв шуудан тасаг |
| 1936-1958 | Холбооны Ерөнхий Хорооны харьяа Төв Шуудан |
| 1958-1960 | Цахилгаан Шуудангийн хороо |
| 1966-1978 | Төв Шуудан |
| 1978-1990 | Цахилгаан Шуудан Холбооны газар |
| 1990-1994 | Шуудан Холбооны газар |
| 1994 | Монгол Шуудан ТӨҮГ |
| 2002 | Монгол Шуудан ХХК |
| 2009 | Монгол Шуудан ТӨХК |
| 2016 | Монгол Шуудан ХК |

## ХУВЬЦААТ КОМПАНИД ШИЛЖСЭН ШИЙДВЭР:

1. Монгол Улсын Их Хурлын 2015 оны “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” 70 дугаар тогтоол
2. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 330 дугаар тогтоол
3. Төрийн өмчийн хорооны 2015 оны “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 594 дүгээр тогтоолуудаар “Монгол Шуудан” ХК болгон өөрчлөв.





# ЦАР ТАХАЛ БА ХЯМРАЛЫН МЕНЕЖМЕНТ






Компани цар тахлын улмаас улс орон даяар бизнесийн байгууллага болон бүх салбарт хүчтэй цохилтыг өгсөн хүндхэн нөхцөл байдлын өмнө яахын аргагүй нүүр тулахаас өөр арга зам байсангүй. Бид энэ цаг үед ажын байрны орон тоог хасах биш харин шаардлагатай ажлын орон тоог шинээр бий болгон ажиллах хүчийг нэмэгдүүлэн Шуудангийн үйл ажиллагааг хэвийн явуулах тасалдал үүсгэхгүй хүртээмжтэй ажиллах зорилтыг тавин ажилтнуудаа халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө, журмуудыг гарган мөрдөж ажиллав.



## АЖИЛТАН

- Ээлжээр ажиллуулах тушаал шийдвэрийг гаргах ажилтнуудыг цагийн хуваарийг уян хатан байдлаар зохион байгуулах.
- Ажлын байрны ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, хоорондын зай барих, амны хаалт, бээлий хамгаалах хэрэгслийг тогтмол ашиглах
- Вакцинжуулалтад хамруулах
- Ажилтнаа зайнаас ажиллуулах

Ковид-19-ын эсрэг вакцинжуулалтад идэвхтэй хамрагдсан.















## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Хямралын үеийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэл
- Эрсдэлийн хариу арга хэмжээнүүдийг авч ажиллах
- Шаардлагагүй зардлуудыг танах, тэвчих

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Логистикийн тээврийн үйлчилгээг 21 аймагт хүртээмжтэй байдлаар үзүүлэх, тээврийн маршрутыг зөв зохион байгуулах
- Хот доторх хүргэлтийн хугацааг багасгах ачааллыг зөв зохион байгуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Улс хоорондын шуудангийн тасалдалгүй хэвийн үйл ажиллагаар хангах
- Шуудангийн үйлчилгээг хүн бүрт эрх тэгш байдлаар хүргэх цогц бодлого



## ЦАР ТАХАЛ БА ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ

### Монгол Шуудан ХК-ийн гадаад шуудангийн зах зээлд эзлэх хувь

| | | |
|---|---|---|
| ГАРАХ ШУУДАН | 65% | 60,491ш |
| ГАРАХ БУУХИА | 38% | 10,982ш |
| ОРОХ ШУУДАН | 25% | 83,007ш |
| ОРОХ БУУХИА | 8% | 4,665ш |

### Дэлхийн шуудан хүргэлтийн чиг хандлага

*Эх сурвалж:
Дэлхийн шуудан холбоо
Тэмдэглэл: 2015 онд
трейндыг харьцуулах
боломжийг олгохын тулд
солилцооны нийлбэрийг
100 болгосон*




● Илгээмж (илгээлт, боодол)

● Уламжлалт үйлчилгээ, бичиг захидал

## МОНГОЛ УЛСЫН ШУУДАН ХҮРГЭЛТИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

2021 он

| | |
|---|---|
| **5,560,600** | 2021 оны эцсийн байдлаар Монгол улсын нийт шуудан илгээмжийн тоо |
| **5,095,590** | Монгол Шуудан ХК-ийн 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт солилцооны тоо |
| **511,800** | Илгээлт, энгийн илгээмж хүргэлтийн үйлчилгээний 2021 оны жилийн эцсийн нийт солилцоо |

| Статистик үзүүлэлт | Нэр төрөл | 2021 он нийт | 2021 он Монгол Шуудан ХК | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ДОТООД ШУУДАН | **Нийт шуудан, илгээмж** | 5,560,600 | 5,095,590 | **91.6%** |
| | **Бичиг захидал** | 929,100 | 865,303 | **93.1%** |
| | **Боодол** | 179,600 | 164,002 | **91.3%** |
| | **Илгээлт** | 274,300 | 130,526 | **47.6%** |
| | **Буухиа** | 109,900 | 99,606 | **90.6%** |
| | **Бизнес захидал** /Мобиком, Скайтел, Хаан банк гэх мэт/ | 736,000 | 736,024 | **100.0%** |
| | **Гибрид шуудан** /шүүх, торгууль/ | 247,300 | 187,887 | **76.0%** |
| | **Хэвлэл** | 3,026,500 | 2,912,242 | **96.2%** |



БИЧИГ ЗАХИДАЛ
**93.1%**

ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА
**96.2%**

ХҮРГЭЛТ ИЛГЭЭМЖ
**57.5%**

**НИЙТ 91.6%**





# 2021 ОНЫ ОНЦЛОХ АМЖИЛТУУД



### 1. Цахим шилжилт

Цахим шилжилтийн хүрээнд компанийн вебсайтыг шинэчлэж, гар утасны апп шинээр хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүллээ






### 6. Сүлжээ ашиглалт

Сумдын үйл ажиллагаа дэмжих сүлжээ ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд Юнител компанитай хамтран ажилласнаар 2020 оны борлуулалттай харьцуулахад **10** дахин нэмэгдүүлэн борлуулалтыг өсгөлөө. Цаашдаа хамтын ажиллагаар өргөжүүлэх зорилгоор шинэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллахаар боллоо.

### 2. Тохижилт үйлчилгээ

Ард санхүүгийн нэгдлийн хөрөнгө оруулалтаар Төв шуудангийн үйлчилгээний салбарт их засварын ажлыг хийж өнгө төрхийг шинэчиллээ.



### 4. Засвар

7 салбарын өнгө төрхийг сэргээж жишиг салбарын засвар хийлээ /22, 23, 24, 37, Булган, Ховд, Говьсүмбэр / аймаг салбаруудын засварыг хийж өнгө төрхийг шинэчлэн үйлчлүүлэгч болон ажилчдад ая тухтай орчныг бүрдүүлэн ажиллав.



### 7. Гараас гарт

Гараас гарт хүргэлтийн үйлчилгээнд зориулж **probox** автомашинаар хүчин чадлаа нэмэгдүүллээ. Ингэснээр цар тахлын үед хэрэглэгчдэд илүү ойртон эрсдэлийг бууруулах хүртээмжтэй үйлчилгээг олон нийтэд хүргэхийг зорин ажиллалаа.




### 3. Шинэ салбар

Улаанбаатар хотод 4 салбар шинээр болон байршил сайжруулан байгууллаа /25, 36, 53, Хүннү молл /








### 5. Хэрэглэгчийн лавлах төв

Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төвийн үйл ажиллагаар өргөжүүлж, операторын тоог нэмэгдүүлэн ажилласнаар үйлчлүүлж буй иргэдийн ачааллыг бууруулах, дуудлагад цаг алдахгүй хариулах санал гомдлыг барагдуулах тал дээр анхаарч ажиллав.



### 8. Гэрээт хүргэгч

Covid-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмийн үед үйлчлүүлэгчийн илгээмжийг А-Б цэгт саадгүй хүргэх, хүргэлтийн үйлчилгээний ачааллыг бууруулах зорилгоор хувь хүмүүс болон такси үйлчилгээний компаниудтай хамтран ажиллалаа.

## 9. E-MONGOLIA

E-Mongolia-р захиалсан 33,964 ширхэг гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг хаягт эзэнд хүргэх ажлыг зохион байгуулан хамтран ажиллалаа.




## 10. Шинэ марк

Монгол улсад орчин цагийн харилцаа холбоо, шуудан мэдээллийн технологийн салбар үүсч хөгжсөний 100-н жилийн ойн хүрээнд 21 сэдвийн шинэ маркийг бүтээж гүйлгээнд оруулан түүхийг мөнхөлж чадсан онцлог жил боллоо.







## 11. Ялган боловсруулах төв

Хөшигийн хөндийд олон улсын стандартад нийцсэн, шуудангийн аюулгүй байдлыг бүрэн хангасан УХШЯБТ-ийг бүрэн ашиглалтанд оруулах ажил хийгдэж байна.

## 13. Санхүүжилт

Дэлхийн шуудангийн холбооны чанарын сангийн санхүүжилтийн хүрээнд шинэ Тоёота Хайс маркийн автомашин хүлээн авлаа.

Дэлхийн Шуудангийн Холбооны техник хамтын ажиллагааны төсөл, чанарын дундын сангийн санхүүжилтээр компьютер, принтер, жин, бусад тоног төхөөрөмжийг худалдан авлаа.





## 12. Тэр бум мод

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд СХД-ийн 24-р хорооны нутаг дэвсгэрт мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн.





## 14. Вакцинжуулалт

Ажилтнуудаа цар тахлын үед урьдчилан сэргийлэх зорилгоор Нийт давхардсан тоогоор **4000** ажилтанг PCR-шинжилгээнд хамруулж Астразеника, Синфарм төрлийн ванкциний 1, 2-р тунд Улаанбаатар хотын **94%**-г орон нутгийн ажилтнуудын **75%**-г амжилттай хамруулж урьдчилан сэргийлж чадсанаар цар тахлын хүнд үед үйл ажиллагаагаа доголдол сааталгүй явуулж чадлаа






## 15. Диплом хүргэлтийн үйлчилгээ

Цар тахлаас шалтгаалж төгсөгчдийн диплом хүргэлтийн үйлчилгээг Монгол шуудангаар дамжуулан эх орны өнцөг булан бүрт суугаа эздийнх нь гарт хүргэх ажлыг зохион байгуулан ажилласнаар 2020 онд нийт 9 сургуулийн **3875** дипломыг хүргэн ажилласан бол 2021 онд **7474**ш дипломыг хүргэн өмнөх онтой харьцуулахад **1,8** дахин нэмэгдэн эздийнх нь гарт саадгүй хүргэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.





Фото зургийг **Төгөл**
*Хэнтий*

МОНГОЛ ШУУДАН

# ХҮНИЙ НӨӨЦ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААР

2021 оны IV-р улирлын байдлаар компанийн хэмжээнд 7 газар, 6 хэлтэс, 6 төв, шуудангийн үйлчилгээний 20 салбар, 22 шуудангийн үйлчилгээний газар, 333 сумдад нийт 997 ажилтан ажиллаж байна.

## Дундаж наслалт




Компанийн ажилтнуудын дундаж насыг сүүлийн 5 жилийн байдлаар харвал 2021 оны байдлаар **35 нас болж залуужсан** харагдаж байна.

## Нийт ажилтны тоо




Хүйсийн хувьд авч үзвэл, **70%** хувь нь эмэгтэй, **30%** хувь нь эрэгтэй ажилтан байна. Энэ нь 2019 онтой харьцуулбал нийт ажилтанд ногдох эрэгтэй ажилтны хувийн жин **2.5%-иар өссөн**.




"Монгол Шуудан" ХК-ийн нийт ажиллах хүчний **47%** нь Улаанбаатар хотод, **53%** нь Аймгийн шуудангийн үйлчилгээний газарт ажиллаж байна.




Ажиллах хүч нь Шуудангийн үйлчилгээний салбар, хэсэг, төвүүдэд буюу **461** Аймгийн шуудангийн үйлчилгээний газарт **536** нийт компанийн хэмжээнд **997** ажилтан байна.




**НИЙТ КОМПАНИЙН ХЭМЖЭЭНД**

**997**

**АЖИЛТАН БАЙНА**

# 2021 ОНЫ ОЛОЛТ АМЖИЛТ



### Монгол Улсын Засгийн Газар, Улсын онцгой комиссоос Монгол Шууданд талархал гардуулан өглөө

Дэлхий нийтэд тархаад буй халдварт цар тахал болох Коронавирус (COV-ID-19) - ын энэ хүнд үед Монгол улсынхаа иргэдийг гамшгаас урьдчилан сэргийлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үйлсэд хичээл зүтгэл гарган, өндөр зохион байгуулалттайгаар хамтран ажилласанд талархал илэрхийлсэн байна.



### Татвар

2020 оны Монгол улсын шилдэг татвар төлөгч 20 аж ахуйн нэгжийн нэг “Монгол Шуудан” ХК шалгарлаа.



**НҮБ-ын мэргэжлийн төрөлжсөн байгууллага болох Дэлхийн Шуудангийн Холбоо (ДШХ) гишүүн орнуудын шуудангийн хөгжлийн индексийг жил бүр шинэчлэн тогтоодог. Энэ жилийн мэдээгээр Монгол Шуудан цар тахлын хүнд нөхцөлд +24.43%-ийн өсөлтийг үзүүлж 2021 онд (2020 оны үзүүлэлтээр) нийт дэлхийн 168 орноос 57 дугаар байр эзэллээ.**






### Шагнал урамшуулал

Монгол улсад орчин цагийн харилцаа холбоо, шуудан мэдээллийн технологийн салбар үүсч хөгжсөний 100-н жилийн ойн хүрээнд 2021 оны 01 сарын 02-ны өдрөөс эхлэн олон жил үр бүтээлтэй, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдөн ажил гүйцэтгэлээрээ бусдаасаа манлайлсан ажилтнуудыг сонгон Төрийн дээд олон медальд тодорхойлох болзол шаардлага хангасан Улаанбаатар, Орон нутаг, газар хэлтэс, салбар, төвүүдээс шагналын материалыг хүлээн авч боловсруулан нийт “Төрийн дээд шагнал” **30 ажилтан** , Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар болон бусад байгууллагын шагналаар Улаанбаатар хотын **138** ажилтан, Аймаг орон нутгийн 100 ажилтан нийт **292** ажилтныг шагнаж урамшуулан баярын үйл ажиллагаар зохион байгуулан ажиллав. Шагнал гардуулах 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Тусгаар тогтнолын ордонд амжилттай зохион байгуулав. ХХМТСалбарын ойн медалийг компанийн 1000 гаруй ажилтан албан хаагч Улаанбаатар хот, АШҮГ-т харьяалагддаг **500** гаруй ахмад нийт **1500** ажилтан албан хаагч, ахмадуудад 100 жилийн ойн медаль болон гарын бэлгийг гардуулан хүргүүлж зохион байгуулалт хийн ажиллалаа.

# ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛАВЛАХ ТӨВ



### 2021 онд нийт 155,130 ш лавлагаанд хариу өгсөн байна

| | |
|---|---|
| Фэйсбүүк чат, коммент | 16198 |
| www.Mongolpost.mn веб сайт | 1431 |
| Утсаар | 134131 |
| Имэйл /customercare@mongolpost.mn/ | 1338 |
| Дуут шуудан / колл про / | 63 |
| Инстаграм | 45 |
| ДШХ-ийн тест дуудлага | 84 |
| УХШ хяналт / лавлагаа илгээсэн, хариулсан / | 882 |
| Эргэж холбогдсон дуудлага | 958 |





## ЛАВЛАХ ТӨВИЙН ОПЕРАТОРУУД ОЛОН УЛСЫН ШУУДАНГИЙН СИСТЕМ GCSS, IPS, I-CARE, POST NET-ДОТООД СИСТЕМ, E-MONGOLIA, MYDELIVERY.MN, MONGOLPOST.MN ЧАТ, FACEBOOK, TWITTER ЧАТ ГЭХ МЭТ ОЛОН СУВАГ САЙТ ДЭЭР АЖИЛЛАЖ ХЭРЭГЛЭГЧИДДЭЭ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ӨГЧ БАЙНА.



Улс хоорондын гарах шуудан илгээмжийг саатлгүй хүргэхэд анхаарч байршлын мэдээлэлд тогтмол хяналт хийж улс хоорондын гарах шууданд 5557, орох шууданд 2901 лавлагааны хариу өгсөн.

Нийтдээ лавлах GCSS, I-Care системээр **8458** лавлагаа илгээсэн байна.

Дэлхийн шуудан холбооны чанарын тест дуудлага, тест мэйлд цаг алдалгүй 364 хариу өгсөн.

2021 оны 1 сараас 11 сар хүртлэх байдлаар нийт **17163** буухиа-10305, илгээлт-4222, бичиг захидал-3120 шуудан хяналт хийснээс хаягт 16679 шуудан гардуулагдсан, буцаагдсан 224 шуудан, хаягт хүргэгдээгүй хүлээгдэж буй-257 шуудан байна.

11 сараас хойших шуудангуудад хяналт хийгээд явж байна. Хянаж буй шуудан илгээмжээ хаягт хүртэл өдөр бүр шалгадаг.






























МОНГОЛ
ШУУДАН

# ЦАХИМ ШИЛЖИЛТ АЖЛЫН ХҮРЭЭНД



### I. E-Mongolia төрийн үйлчилгээ

- E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системээс 2 шатлалт үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд E-Mongolia төслийн хөгжүүлэгч Аствишн, УБЕГ-тай гурвалсан уулзалтууд хийж, цонхтой дугтуй, хаягийн хуудас хэвлэх, хүлээлцэх акт зэрэг үйлчилгээний процессийг тохиролцов. Эхний шатанд нэвтрүүлэх **30** үйлчилгээний тестийн ажлууд эхэлсэн байна.
- E-Mongolia хоёр шатлалт үйлчилгээнд зориулж шинээр service хөгжүүлсэн. Үйлчилгээ нэвтрүүлж эхэлсэн. Харилцагчийн бүртгэл нэмэгдсээр байх тул сайжруулах процесс цаашид тасралтгүй хийгдэх болно. Одоогийн байдлаар доорх байгууллагууд E-Mongolia системээс API-р мэдээллээ илгээж, хүргэлт хийлгэж байна. Үүнд:

1. Цагдаагийн ерөнхий газар
2. УБЕГ
3. Дорнод аймгийн УБЕГ
4. Өмнөговь аймгийн УБЕГ
5. Хил хамгаалах ерөнхий газар
6. Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар
7. Гадаадын иргэн, харьяатын газар

### II. Дотоод шуудан бүртгэлийн Постнет V4 системийн хөгжүүлэлт эхэлсэн

- Шуудангийн технологийн шинэчлэл
- ПХ технологийн шинэчлэл
- Аппликейшн хөгжүүлэлт





### III. Байгууллагын вэб сайт шинэчлэн хөгжүүлсэн

- Онлайн захиалга хүлээн авах, хаягаар очиж авах үйлчилгээ нэмэгдсэн.
- Тус хөгжүүлэлтийн ажилд байгууллагын үндсэн сайт **mongolpost.mn**, маркийн онлайн худалдааны сайт **mongolstamps.mn**, онлайн хэвлэл захиалгын сайт **postnews.mn** гэсэн 3 сайтыг шинэчлэх ажил хийгдэж байгаа.

Үндсэн сайт 100%

хэвлэлийн сайт 90%

маркийн сайт 50%

гүйцэтгэлтэй явагдаж байна.




### IV. Мобайл аппликейшн хөгжүүлэн, амжилттай нэвтрүүлсэн

Андройд болон IOS үйлдлийн системд зориулсан хэрэглэгчийн мобайл аппликейшн амжилттай нэвтрүүлсэн. Тус аппликейшнийг ашиглан:

- Дотоод, гадаад шуудангийн захиалга өгөх,
- Үнэ тооцоолох,
- Салбарын байршил, ажлын цаг
- Тээврийн хуваарь,
- Илгээмжийн байршил шалгах,
- Мэдээ мэдээлэл авах боломжтой.



# ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

## УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ ТАЛААР



### Стандартуудын мөрдөлтийг хангах, хүргэлтийг сайжруулах

Дэлхий даяар цар тахлаас шалтгаалсан хүндрэлүүд үүсч, дэлхийн улс орнууд давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд автсанаа зарласан бөгөөд ДШХ болон Буухиа шуудангийн кооперативаас хийлгэдэг 2020-2021 оны чанарын үнэлгээг цуцалсан. Иймээс цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан улс хоорондын шуудангаар гарч буй аливаа хүндрэл бэрхшээл, шуудангийн саатлыг арилгах тал дээр анхаарч ажилласан бөгөөд мөн стандартуудын мөрдөлтийг хангах зорилт тавин ажиллалаа.



### Тээврийн маршрутыг оновчлох

МИАТ, Туркиш Эйрлайнс, Эйр Инчеон, Кореан Эйр, АНА компаниудтай нягт хамтран ажилласнаар 2021 оныг дуустал 96 удаагийн нислэгээр, 20 гаруй улсад давхардсан тоогоор 527 чиглэлд шуудан гаргалаа. Улс орнууд руу илгээж буй бүх төрлийн илгээмжийн маршрут чиглэлийг тухай бүрт өөрчлөх, дамжин өнгөрүүлэх улс орны шуудангууд болон тээврийн байгууллагатай удаа бүрт нь холбогдон ажиллалаа.



### Хүргэлтийн саатлыг бууруулах

Гарах буухиа шуудангийн хүргэлт гардуулалтын явц дунд гарсан төлөвлөгдөөгүй саатал үүссэн нөхцөл байдлыг илгээгчид тухай бүрт мэдэгдэж, саатлыг арилгах боломжуудыг эрэлхийлж, асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.








### Илгээмжийн аюулгүй байдлыг сайжруулах

Дэлхийн Шуудангийн Холбооны стандартын дагуу олон улсын хариу бичиг захидлын купон, зураасан код, маягт, богцны лац зэрэг шуудангийн хэрэглэгдэхүүнийг БНХАУ болон Щвейцарь улсад захиалан хийлгүүлэв.



### Технологийн зөрчилгүй ажиллах

Улс хоорондын шуудангийн бүх шат дамжлагуудад аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор заавар зөвлөмжүүдийг дотоод мэдээллийн сайт дээр байршуулах, дотоод сүлжээгээр анхааруулж мэдээлэн ажилласан ба нийт 357 зөрчлийг илрүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллалаа.



Мөн улс хоорондын сүлжээний болон илгээмжийн аюулгүй байдлыг хангаж, УХШИГГ, Хилийн мэргэжлийн хяналт хамтран ажиллалаа.

Болзошгүй зөрчил, гэмт хэргээс сэргийлж ажиллах талаар улирал тутам зааварчилгаа өгч, хяналтын бүсэд ажилладаг ажилтан бүрээр баталгаа гаргуулан ажилласан бөгөөд зөрчил дутагдал гаргасан ажилтнуудад зохих хариуцлагыг тооцон арга хэмжээ авч ажилласан.



# УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

## 2021 ОНЫ УЛС ХООРОНДЫН ГАРАХ ШУУДАНГИЙН СОЛИЛЦООГ 2020 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД

### Гарах илгээмж

| НИЙТ | 2020 | 2021 |
|---|---|---|
| Тоо ширхэг | 62414 | 54528 |
| Жин /кг/ | 134951 | 203434 |

Илгээмжийн тоо хэмжээ нь 12.6 %-иар буурсан хэдий ч жингийн тухайд 50.7 %-иар өссөн байна.

2021 онд 96 удаагийн нислэгээр, 527 чиглэлд (давхардсан тоогоор) 203434 кг шуудан экспортолжээ.

### Орох илгээмж

| НИЙТ | 2020 | 2021 |
|---|---|---|
| Тоо ширхэг | 84828 | 88869 |
| Жин /кг/ | 55830 | 68620 |

2021 оны улс хоорондын орох шуудангийн солилцоог 2020 онтой харьцуулахад илгээмжийн тоо хэмжээ нь 4.8 %-иар, жингийн тухайд 22.9 %-иар нэмэгдсэн байна.



# ДОТООД ШУУДАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА





## ШУУДАН СОЛИЛЦООНЫ БҮРТГЭЛ, СУДАЛГАА

Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд орох, гарах чиглэлд 258566 ширхэг богц буюу 1666,2 тн шуудан ялган боловсруулж, өөрийн тээврээр бүх аймагт шуудан хүргэлээ.

БУУХИА ШУУДАН 9,1378 ШИРХЭГ

БИЧИГ ЗАХИДАЛ 1,575,508 ШИРХЭГ

БООДОЛ 250,736 ШИРХЭГ

ИЛГЭЭЛТ 166,129 ШИРХЭГИЙГ

хүлээн авч, ялган боловсруулж, хүргэсэн нь илгээмжийн солилцоо түүхэндээ анх удаа 2,083,751 ширхэгт хүрсэн байна. Хэвлэлийн солилцоо 2,857,684 ширхэгийг тус тус ялган боловсруулж, хүргэжээ.

2,083,751

**Илгээмжийн солилцоо түүхэндээ анх удаа**

Солилцоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад илгээмжийн солилцоо 2,8%-иар өссөн, хэвлэлийн 45,6%-иар буурсан, илгээмжийн хүндийн жин 62,2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

### Солилцооны мэдээ






# ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

## ХОТ ДОТОРХ ХҮРГЭЛТ - ГАРААС ГАРТ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



2021 оны 2-р сараас парк шинэчлэл хийн **хүргэлтийн авто машины тоог нэмэгдүүлж** ачаалал нэмэгдсэн үед **Гэрээт жолоочийг** ажиллуулав.

Системийн хөгжүүлэлтийг хийж салбар болон орон нутагт илгээсэн илгээмжийн **дагавар** болон шуудангийн **хүргэлтийн дэвтрийг** системээс хэвлэдэг болгосон.

Шинээр жолооч, үйлчилгээний ажилтан, болон гэрээт жолооч нарыг ажлын байранд дадлагажуулсан. Нийт ажилтнуудад "Үйлчилгээний стандарт" чиглэлээр сургалт, ШУГ, ШУС ын ажилтнуудад сургалт хийв.








### Улс хоорондын транзит шуудангийн үйлчилгээ

Эрээн-Алтан булаг чиглэлд автозамын тээвэрлэлт, Алтан булаг-Улаанбаатар чиглэлд том оврын ачааны машинаар тээвэрлэлтийг зохион байгуулан ажиллав.

**Эрээн-Улаанбаатар** чиглэлд машинаар, **Улаанбаатар-Наушки** чиглэлд төмөр замаар тээвэрлэлтийг гүйцэтгэв.



Замын Үүд боомт хаагдсантай холбоотойгоор транзит шуудангийн тасралтгүй байдлыг хангаж БНХАУ-ОХУ чиглэлд өмнөх оноос өссөн дүнгээр нислэг зохион байгуулав.



### Хот хоорондын тээвэр, логистикийн үйлчилгээ

Улаанбаатараас 21 аймаг, алслагдсан 3 дүүрэг, томоохон сумуудын шуудан, ачаа 7 хоногт 1-5 удаагийн давтамжтайгаар тээврийг зохион байгуулав



Хот хоорондын тээврээр Улаанбаатар хотоос өмнөх онтой харьцуулахад 1,8 дахин илүү тн шуудан, логистикийн ачааг орон нутагт хүргэв. Орон нутгаас Улаанбаатар чиглэлд өмнөх онтой харьцуулахад 1,6 дахин илүү мах, ачаа, шуудanг тээвэрлэн гүйцэтгэв.

2021 оны 3-р улирлаас жижиглэн ачаануудыг **Postnet** програмд бүртгэн, богцолж явуулдаг болсноор ачаа бараа алга болох, гэмтэх, бүртгэлгүй илгээмж явуулах зэрэг зөрчлүүдийг бууруулсан.



# САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АЖЛЫН ХҮРЭЭНД

## МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

“Монгол шуудан” ХК нь Ард Кредит ББСБ-тэй хамтран Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ Еврожайро системд нэгдсэнээр 2021 онд нийт 842 удаагийн давтамжтайгаар 2,168,312,074.08₮-н гүйлгээг амжилттай хийгээд байна. Бид цаашдаа мөнгөн гуйвуулгын үйлчилгээг илүү өргөжүүлэх хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон орон нутгийн шуудан үйлчилгээний салбаруудаар үзүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

| | 2020 | 2021 |
|---|---|---|
| Давтамж | 75 | 842 |
| Дүн | **113,406,255.15** | **2,168,312,074.84** |
| Улсууд | 13 | 38 |





# МАРК

## ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН 100 ЖИЛ

ЦАХИМ ҮНДЭСТЭН

## 2021 ОНД ШУУДАНГИЙН ГҮЙЛГЭЭНД ГАРСАН МАРКУУД:



ҮХЭР ЖИЛ



ЗСБНХУ–БНМАУ САНСАРЫН ХАМТАРСАН НИСЛЭГ 40 ЖИЛ



ШИНЭ ҮЕИЙН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО ХӨГЖСӨНИЙ 30 ЖИЛ



МОНГОЛЫН ТУЛГАР ТӨР – 2230 ЖИЛ



МОНГОЛ УЛСАД БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТ БАЙГУУЛАГДСАНЫ 30 ЖИЛ



АРДЫН ХУВЬСГАЛЫН 100 ЖИЛ



ПРАГИЙН АМЬТНЫ ХҮРЭЭЛЭН – ЗҮҮН ГАРЫН ГОВЬ



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН 100 ЖИЛ



МАНЛАЙ БААТАР Ж.ДАМДИНСҮРЭНГИЙН МЭНДЭЛСНИЙ 150 ЖИЛИЙН ОЙ



МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 100 ЖИЛИЙН ОЙ



МОНГОЛ ДАХЬ АНУ-ЫН ЭНХ ТАЙВНЫ КОРПУСЫН 30 ЖИЛИЙН ОЙ





МОНГОЛ УЛС НҮБ-Д ЭЛССЭНИЙ 60 ЖИЛИЙН ОЙ



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН 100 ЖИЛ



ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН 100 ЖИЛ



ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН 100 ЖИЛ



ОРЧИН ЦАГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ 100 ЖИЛ



ОРЧИН ЦАГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 100 ЖИЛ



ЮНЕСКО-ИЙН ДЭЛХИЙН ДУРСАМЖ ХӨТӨЛБӨРТ БҮРТГЭГДСЭН БАРИМТАТ ӨВҮҮД



МОНГОЛЫН ЭСТАРД УРЛАГ

# ДУГТУЙ



МОНГОЛ ДАХЬ АНУ-ЫН ЭНХ ТАЙВНЫ КОРПУСЫН 30 ЖИЛИЙН ОЙ



МОНГОЛЫН ТУЛГАР ТӨР – 2230 ЖИЛ



МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 100 ЖИЛИЙН ОЙ



ЮНЕСКО-ИЙН ДЭЛХИЙН ДУРСАМЖ ХӨТӨЛБӨРТ БҮРТГЭГДСЭН БАРИМТАТ ӨВҮҮ



МОНГОЛ УЛС НҮБ-Д ЭЛССЭНИЙ 60 ЖИЛИЙН ОЙ



ҮХЭР ЖИЛ



ЗСБНХУ–БНМАУ САНСАРЫН ХАМТАРСАН НИСЛЭГ 40 ЖИЛ



ПРАГИЙН АМЬТНЫ ХҮРЭЭЛЭН – ЗҮҮН ГАРЫН ГОВЬ



МОНГОЛ УЛСАД БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТ БАЙГУУЛАГДСАНЫ 30 ЖИЛ



ШИНЭ ҮЕИЙН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО ХӨГЖСӨНИЙ 30 ЖИЛ





МОНГОЛЫН ЭСТАРД УРЛАГ



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГИЙН 100 ЖИЛ



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН 100 ЖИЛ



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН 100 ЖИЛ



АРДЫН ХУВЬСГАЛЫН 100 ЖИЛ



ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН 100 ЖИЛ



ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН 100 ЖИЛ



ОРЧИН ЦАГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 100 ЖИЛ



ОРЧИН ЦАГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ 100 ЖИЛ






# ШУУДАНГИЙН НИЙТ СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2017-2021 он | ширхэг

| | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|
| **НИЙТ СОЛИЛЦОО** | **1,662,660** | **2,397,599** | **2,653,661** | **2,399,497** | **2,410,063** |
| **ДОТООД** | **1,193,531** | **1,685,703** | **2,082,944** | **2,108,296** | **2,183,348** |
| Бичиг захидал | 1,122,595 | 1,512,814 | 2,009,719 | 2,002,527 | 1,867,891 |
| Боодол | 46,054 | 55,928 | 51,766 | 60,102 | 168,646 |
| Илгээлт | 24,882 | 21,961 | 21,459 | 45,667 | 146,811 |
| **УЛС ХООРОНД** | **469,129** | **711,896** | **570,717** | **291,201** | **226,715** |
| Улс хооронд Гарах | 204,502 | 177,930 | 191,276 | 60,491 | 54,223 |
| Улс хооронд Орох | 264,627 | 533,966 | 379,441 | 230,710 | 172,492 |




**Нийт солилцоо:**
2021 онд өмнөх жилээс **0.4** хувиар өссөн

## Дотоод шуудангийн солилцооны үзүүлэлт

**Дотоод нийт солилцоо:** 2021 онд өмнөх жилээс **3.6** хувиар өссөн




## Улс хоорондын шуудангийн солилцооны үзүүлэлт

**Гадаад нийт солилцоо:** 2021 онд өмнөх жилээс **22.1** хувиар буурсан







## Орлого, цэвэр ашиг

2017-2021 он | сая.төгрөг

| Дансны нэр | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 13,672.6 | 15,474.0 | 16,725.0 | 18,231.9 | 20,932.8 |
| Татварын дараах цэвэр ашиг | 1,224.2 | 1,560.3 | 1,103.6 | 557.9 | 400.0 |

## Нийт орлого




## Татварын дараах цэвэр ашиг



## Нийт хөрөнгө

сая.төгрөгөөр




Тус компанийн **нийт активийн хэмжээ** 2021 оны жилийн эцэст 32,095.0 сая төгрөгт хүрч урьд оныхоос 14.1 хувиар буурсан байна

Хувиар




**Компанийн эргэлтийн хөрөнгө** 2020 онд нийт хөрөнгийн 73.9 хувийг эзэлж байсан бол 2021 онд 69.6 хувь болон буурсан байна

## Нийт өр төлбөр ба эздийн өмч

сая.төгрөгөөр




хувиар




2021 оны жилийн эцсийн **богино хугацаат өр төлбөр** 7,309.4 сая төгрөгт хүрч, өмнөх жилээс 45.4 хувиар буурсан бол **хуримтлагдсан ашгийн хэмжээ** 4,608.1 сая төгрөгт хүрч, 2021 оноос 4.1 хувиар өсчээ

## Санхүүгийн харьцаа үзүүлэлт

2020-2021 он

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| **ЦЭВЭР АШИГ** | **төгрөг** | **557,893,342.52** | **400,046,154.68** |
| Нийт хувьцааны тоо | ширхэг | **99,586,363** | **99,586,363** |
| Нэгж хувьцааны үнэ | төгрөг | **750.0** | **1,350.0** |
| Нэгж хувьцааны дансны үнэ | төгрөг | **248.8** | **248.9** |
| Зах зээлийн үнэлгээ | тэрбум төгрөг | **74.7** | **134.4** |
| Нэгж хувьцааны өгөөж /EPS/ | төгрөг | **5.60** | **4.02** |
| Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ | - | **0.0149** | **0.0125** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROA/ | - | **0.0233** | **0.0161** |
| **Нийт хөрөнгийн эргэц /ROTA/** | - | **0.0149** | **0.0147** |



## Хувьцааны хоёрдогч зах зээл дээрх арилжаа

2021 он

ӨНГӨРСӨН 2021 ОНД КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЛИЙГ (ХААЛТЫН ХАНШ) ХАРВАЛ:

### ХУВЬЦААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

| | |
|---|---|
| 2021 онд нийт 247 өдрийн арилжаанд идэвхтэй байж | 2021.01.04 - **700.0** төгрөгийн нээлтийн ханштайгаар эхэлж |
| | 2021.12.31 - **1,350.0** төгрөгт хүрч тайлант оны арилжааг хаалаа |

Компанийн Хөрөнгийн бирж дээрх үнэлгээ **74.7** тэрбум төгрөгөөс оны эхсийн байдлаар **80.0** хувиар өсч **134.4** тэрбум төгрөгт хүрээд байна.

## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2020-2021 он

2021 оны жилийн эцсийн байдлаар компанийн нийт хувьцааны
66 хувийг Төрийн өмч,
23.6 хувийг Ард Санхүүгийн Нэгдэл ба түүний хамаарал бүхий этгээд,
10.4 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

| | 2020 | 2021 |
|---|---|---|
| **Төрийн өмч** | 66% | 66% |
| **Ард Санхүүгийн Нэгдэл** | 30.94% | 23.60% |
| **Бусад** | 3.06% | 10.40% |








# АУДИТЫН ТАЙЛАН

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18-р зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**Тайлант хугацаа:** 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт

| | | 2020.12.31 | **2022.12.31** |
|---|---|---|---|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 21,058,975,785.26 | 14,304,012,274.34 |
| 1.1.2 | Дансны авлага | 2,067,693,154.84 | 1,561,147,844.30 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 10,031,256.50 | 7,959,558.98 |
| 1.1.4 | Бусад авлага | 512,055,439.37 | 208,294,306.99 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 7,769,001.00 | 7,769,001.00 |
| 1.1.6 | Бараа материал | 2,553,870,300.61 | 2,778,743,420.48 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1,395,652,267.27 | 3,478,342,480.47 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **27,606,047,204.85** | **22,346,268,886.56** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | **0.00** | **0.00** |
| **1.2.1** | **Үндсэн хөрөнгө** | 8,252,460,198.96 | 8,522,799,977.58 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,507,283,452.68 | 1,225,448,481.99 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 500,000.00 | 500,000.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.00 | 0.00 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **9,760,243,651.64** | **9,748,748,459.57** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,366,290,856.49** | **32,095,017,346.13** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 12,553,826,567.10 | 6,062,957,616.02 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.00 | 35,000.51 |



2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гарсан.

Төгрөг

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.1.3 | Татварын өр | 137,217,133.61 | 238,806,355.76 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 0.00 | 795,786.83 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 433,009,216.64 | 463,892,631.47 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | 0.00 | 0.00 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 265,758,032.37 | 548,527,942.84 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **13,389,810,949.72** | **7,314,979,333.43** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 0.00 | 0.00 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 0.00 | 0.00 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 0.00 | 0.00 |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **0.00** | **0.00** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **13,389,810,949.72** | **7,314,979,333.43** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 6,572,700,000.00 | 6,572,700,000.00 |
| 2.3.2 | - хувийн | 3,385,936,300.00 | 3,385,936,300.00 |
| 2.3.3 | - хувьцаат | 0.00 | 0.00 |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | 0.00 | 0.00 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 2,538,512,210.45 | 2,538,512,210.45 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,379,919,523.85 | 3,379,919,523.85 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 0.00 | 0.00 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 3,676,789,311.73 | 4,300,458,597.23 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 4,425,622,560.75 | 4,602,511,381.17 |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **23,976,479,906.78** | **24,780,038,012.70** |
| | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **37,366,290,856.50** | **32,095,017,346.13** |

## АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

**Тайлант хугацаа:** 2021-12-31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

Төгрөг

| | Үзүүлэлт | 2020.12.31 | **2021.12.31** |
|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **16,355,718,391.34** | **19,838,796,351.51** |
| 2 | Борлуулалтын өртөг | 16,655,138,083.86 | 19,328,556,601.34 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **(299,419,692.52)** | **510,239,750.17** |
| 4 | Түрээсийн орлого | 120,128,315.75 | 103,289,121.67 |
| 5 | Хүүний орлого | 720,248,122.37 | 406,304,998.11 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 0.00 | 0.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 0.00 | 0.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 860,136,874.60 | 917,446,523.39 |
| 11 | Санхүүгийн зардал | 0.00 | 0.00 |
| 12 | Бусад зардал | 86,724,031.47 | 215,189,538.24 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 1,035,328,449.34 | 566,539,914.40 |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | 493,865.89 | 17,882,888.57 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **629,918,154.76** | **471,620,611.29** |
| 19 | Орлогын татварын зардал | 72,024,812.24 | 71,574,456.61 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **557,893,342.52** | **400,046,154.68** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **557,893,342.52** | **400,046,154.68** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | **0.00** | **0.00** |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 0.00 | 0.00 |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 0.00 | 0.00 |
| **24** | **ОРЛОГЫН НИЙТ ДҮН** | **557,893,342.52** | **400,046,154.68** |

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Тайлант хугацаа:** 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Төгрөг

| | Үзүүлэлт | 2019.12.31 | **2020.12.31** |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **117,563,837,056.08** | **102,131,088,744.62** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 14,934,544,126.53 | 20,116,138,649.08 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 8,309,399.80 | 13,686,589.77 |
| | Буцаан авсан албан татвар | 341,852.00 | 415,286.40 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 3,724,050,463.00 | 3,577,925,614.00 |
| | Бусад мөнгөн орлого | 98,896,591,214.75 | 78,422,922,605.37 |
| 1.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **113,488,133,606.84** | **105,997,364,812.61** |
| | Ажиллагчдад төлсөн | 6,927,674,591.59 | 7,576,084,212.43 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,976,469,979.84 | 2,269,634,977.60 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,339,771,129.81 | 2,576,691,055.82 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 1,339,415,155.89 | 1,435,630,830.97 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 4,361,498,754.90 | 2,640,000,864.29 |
| | Хүүний төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 1,033,489,574.41 | 1,418,040,429.93 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 50,489,205.98 | 95,730,064.77 |
| | Бусад мөнгөн зарлага | 95,459,325,214.42 | 87,985,552,376.82 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **4,075,703,449.24** | **(3,866,276,067.99)** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **948,348,112.46** | **347,838,409.42** |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |

Төгрөг

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | | | |
|---|---|---|---|
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.00 | 0.00 |
| | Хүлээн авсан хүүний орлого | 948,348,112.46 | 347,838,409.42 |
| | Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,529,755,538.61** | **1,678,712,634.65** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,501,305,538.61 | 1,466,209,639.30 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 28,450,000.00 | 202,503,995.35 |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | 9,999,000.00 |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(730,364,522.19)** | **(2,204,930,728.58)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | 0.00 | 0.00 |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| | Төрөл бүрийн хандив | 0.00 | 0.00 |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 0.00 | 0.00 |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **317,441,948.34** | **161,552,422.37** |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 0.00 | 0.00 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 0.00 | 0.00 |
| | Төлсөн ногдол ашиг | 317,441,948.34 | 161,552,422.37 |
| | Бусад | 0.00 | 0.00 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(317,441,948.34)** | **(161,552,422.37)** |
| **4** | **Валютын ханшийн зөрүү** | **1,382,161,352.45** | **(522,204,291.98)** |
| **5** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **4,410,058,331.16** | **(6,754,963,510.92)** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **16,648,915,943.48** | **21,058,975,785.26** |
| **7** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **21,058,975,785.26** | **14,304,012,274.34** |





## АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**Тайлант хугацаа:** 2021 оны 12 дугаар сарын 31-ний 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | **Нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 2,710,106,959.73 | 4,336,419,065.63 | **22,923,594,059.60** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | (151,247,899.03) | **(151,247,899.03)** |
| **Залруулсан үлдэгдэл** | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 2,710,106,959.73 | 4,185,171,166.60 | **22,772,346,160.60** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0,00 | 0,00 | 0,00 | 963,682,352.00 | 0,00 | **963,682,352.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | 557,893,342.52 | **557,893,342.52** |
| Зарласан ноогдол ашиг | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | (317,441,948.37) | **(317,441,948.37)** |
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 3,673,789,311.73 | 4,425,622,560.75 | **23,976,479,906.78** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 400,046,154.68 | **400,046,154.68** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0,00 | 0,00 | 0.00 | 626,669,285.50 | (55,789,334.26) | **570,879,951.24** |
| Зарласан ноогдол ашиг | | | | | (167,368,000.00) | **(167,368,000.00)** |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 9,958,636,300.00 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 4,300,458,597.23 | 4,602,511,381.17 | **24,780,038,012.70** |

Тэмдэглэл



TheMongolPost
Монгол шуудан /Mongol shuudan/
www.mongolpost.mn

Дизайныг Номун Ерөөл ХХК-д


**“МОНГОЛ ШУУДАН” ХК**

Сүхбаатарын талбай–9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х–1106,
Улаанбаатар–15160, Монгол улс

+(976) 1800–1613

info@mongolpost.mn